

**“ЭМЭГТЭЙН ЦУС БҮРЭЛДСЭН” ӨВЧНИЙГ СУРВАЛЖ БИЧГҮҮДЭД ХЭРХЭН ТЭМДЭГЛЭСНИЙГ  
ХАРЬЦУУЛАН АВЧ ҮЗЭХ НЬ**

П.Цэрэннадмид<sup>1,2</sup>, Э.Түмэнжин<sup>2</sup>, Б.Буянт<sup>1</sup>

<sup>1</sup>Өвөр монголын үндэстний их сургууль

<sup>2</sup>Анагаахын шинжлэх ухааны үндэстний их сургууль, МАУОУ Сургууль

\*tseegiitsee179@yahoo.com Утас: 91811828

**A COMPARISON OF GYNECOLOGICAL QISU SYNDROMES IN PREVIOUS REPORTS**

Tserennadmid P<sup>1,2</sup>, Tumenjin E<sup>2</sup>, Buyant B<sup>1</sup>

<sup>1</sup>Inner Mongolia University for Nationalities

<sup>2</sup>Mongolian National University of Medical Sciences, Mongolian International School of Medicine

\*tseegiitsee179@yahoo.com Phone: 91811828

Урлаг, Шинжлэх Ухаан, Тусламж, Өвчин, Эмэгтэйчүүдэд Хэрхэн Тэмдэглэснийг Харьцуулан Авч Үзэх нь

**ABSTRACT**

**Introduction:** Women's disease slows down and becomes chronic, causing diseases that spread throughout the body and affect the organs.

**Objective:** To compare and contrast the treatment of gynecological “Qisu” syndromes in previous reports.

**Methods:** “Four medical tantras” and other sources were the main material. The article was written using search methods, comparison methods, and analysis-synthesis methods. The topic and methodology of the research was approved at the Inner Mongolia University for Nationalities. No conflict of interest.

**Conclusion:** 1. In the “Four medical tantras”, the general symptoms and each category of gynecological “Qisu” syndromes, the prescriptions for each treatment are described in detail, and the treatment is clearly written. 2. In the “Four medical tantras”, Lhantav, Durvun Rashaan, Khukh Binderiiya, Jiduininnor, and the Encyclopedia of Chinese Medicine /Mongolian Medicine/, the gynecological “Qisu” syndromes are described by each category, and the treatment prescriptions are analyzed and written in detail. In other sources, treatment is based on general symptoms. The treatment of gynecological “Qisu” syndromes includes 33 names of drugs medicines. In the general treatment gynecological “Qisu” syndromes in most of the reports, Chatsargana-17, Gishuune-6, 14, 17, Basberuu-7, Zomshin-4, 6, 7, Ooyu-13, Yaanag nukhur-13, Jonsh-11, Melreg tsetseg-7, Brai-sum-17, Rashnamjil, Dedbon-14, Agshirga-3, Jambrai-6 drugs are mentioned and the treatment of each category is coordinated with the condition. 3. Gynecological “Qisu” syndromes is a disease of the whole body characterized by the majority of blood and bile /mkhris pa/. Dispersing the disease with blood, the internal organs vascular diseases is damaged in a different way, and the blood characteristic is predominant, and the bile/mkhris pa/ is combined, internal organs vascular diseases.

**Keywords:** Gynecological “Qisu” syndromes, internal organs vascular diseases, female reproductive disease.

**Үндэслэл:**

Судлын өвчинд хамаарагдах цус бүрэлдсэн зонхилон тохиолдож байгаа бөгөөд өвчин, хий бүрэлдсэн өвчин эмэгтэйчүүдэд

эмэгтэйчүүд толгой өвдлөө, зүрх өвдлөө гэж ирдэгээс биш өвчний онош нь цус бүрэлдсэн, хий бүрэлдсэн өвчин гэдгийг мэддэггүй. Тиймээс нэлээд хүндэрсэн шатандаа ирж эмчлүүлэх нь бий<sup>1</sup>.

Эмэгтэйчүүдийн өвчин удааширч архаг байдалд шилжсэний улмаас бүх биед тархан цул сав эрхтэнд нөлөөлж үүсдэг өвчин юм. Өвчний гэм нь цусны эргэлтээр бүх биеийн өвчнийг үүсгэдэг болохоор судасны өвчин буюу цус бүрэлдсэн гэж нэрлэдэг. Хавсарч, хурах зэрэг хувиралт ихтэй тул оношлох эмчлэхэд бэрхшээлтэй байдаг<sup>2</sup>.

Монгол анагаах ухааны эртний сурвалж бичигт эмэгтэйн өвчнийг ерөнхийд нь умайн өвчин таван зүйл, судлын өвчин арван зургаан зүйл, бэтгийн өвчин есөн зүйл, хорхойн өвчин хоёр зүйл лугаа эмэгтэйн гол өвчин гучин хоёр зүйл зэргээр өгүүлсэн байна<sup>3,4</sup>. Үүнд эмэгтэйн гол өвчин гучин хоёр зүйлээс умайн өвчин хий, шар, бадган, цус, хурмал зэрэг таван зүйлийг нууцын өвчний агуулгад өгүүлээд, бусад хорин долоон зүйлийн гол өвчин дахь судлын өвчин арван зургаан зүйлийг цус бүрэлдсэн арван зүйл, хий бүрэлдсэн өвчин зургаан зүйл хэмээн онцлон ялган танилцуулжээ<sup>4</sup>. Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчин бол эмэгтэйн бүрэлдсэн өвчний эхний шинэ шатанд илэрдэг. Хэдийгээр эртний монгол эмнэлгийн судар бичигт эмэгтэйн цус бүрэлдсэн өвчнийг нарийн ялгаж тэмдэглэж байгаа боловч орчин үеийн эмчилгээнд олонхдоо европ эмнэлгээр оношлон эмчлэхээс биш монгол эмнэлгээр оношлон эмчлэх нь маш цөөхөн болсон буюу цаашилбал монгол эмнэлгээр оношлон эмчлэхгүй орхигдох хандлага ажиглагдаж байгаа нь судалгаа хийх үндэслэл болсон юм.

**Зорилго:** Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчнийг сурвалж бичгүүдэд өвчний тухай ойлголт, ангилал, эм найрлага зэрэг агуулгыг тодорхойлон харьцуулан судлах.

### Зорилт:

1. “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиол дахь “эмэгтэйн цус бүрэлдсэн” өвчний өвөрмөц зүйл ялгааг тодруулах
2. “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолд эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний эмэн эмчилгээг хэрхэн тэмдэглэснийг бусад зохиолуудтай харьцуулах
3. Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний мөн чанарыг илрүүлэх

### Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:

“Анагаах ухааны дөрвөн үндэс<sup>5</sup> зохиол болон бусад Монгол эмнэлгийн рашааны хумх<sup>6</sup>, Дугаржавын эмчилгээний эмчилгээний туршлага<sup>7</sup>, Сарангэрэлт эмчилгээний ном<sup>8</sup>, Эрдэнийн эрхэсийн зуун анхаарлын бичиг оршвой<sup>9</sup>, 18-гишүүнт /2дугаар дэвтэр/<sup>10</sup>, Монгол эмнэлгийн дөхөм найруулга<sup>11</sup>, Увидасын далайн дөрвөн түлхүүр<sup>12</sup>, Данзанванжил Төвдөнням эмчилгээний жор засал<sup>13</sup>, Арүрийн прэнбай<sup>14</sup>, Анагаах ухааны тус амгалангын эрдэнийн хөмрөг<sup>15</sup>, Монгол оточын таван зохиол<sup>16</sup>, Ван Жу Во-гын эмчилгээний үйлвэр<sup>17</sup>, Тунгаагажид<sup>18</sup>, Увидасын далай<sup>19</sup>, Гарын авлагад туслах рашааны эмийн найрлага<sup>20</sup>, Лхантав<sup>21</sup>, Дөрвөн рашаан<sup>22</sup>, Хөх биндэрьяа<sup>23</sup>, Жидүйниннор<sup>24</sup>, Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь, /Монгол анагаах ухаан/<sup>25</sup> зэрэг зохиолуудыг материал болгосон бөгөөд арга зүйн хувьд:

### Сурвалж бичгийг эрэх арга:

Эртний сурвалж бичгүүдээс цус бүрэлдсэн өвчний тухай тэмдэглэсэн сурвалж бичгийг эрэн хайж, тэмдэглэл хөтлөх.

### Харьцуулах арга:

Сурвалж бичгүүд дахь цус бүрэлдсэн өвчний ангилал, ерөнхий болон тус бүрийн эмэн эмчилгээг харьцуулах.

**Анализ, синтезийн арга:**

Энэ арга нь эх сурвалжаас түүний агуулганд шууд хамаарах дүгнэлт гаргахад чиглэсэн судалгааны арга юм. Эх бичвэр, сурвалж бичгийн агуулгыг тоон болон чанарын гэх мэтээр ангилан судалдаг. Бид энэхүү аргыг анагаах ухааны сурвалж бичгүүдийг түүвэрлэн тогтоох, эмчилгээний жорыг ерөнхий болон тус бүрийн эмчилгээнд тохируулахад голлон ашигласан.

**Үр дүн:****1. “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолд эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний талаарх өвөрмөц онцлог:**

Ерөнхий шинж: Бэлхүүснээс доош яс шархиран өвдөх, гэдэсний доор халуун оргиж өвдөх, элэг хатгуулах, судлын халуун долгисох, нясуу гүвдрүү болно. Умайгаас цус цувирах ба хорхой хийгээд өгөр болно<sup>5</sup>.

**Ангилал:**

1. Зүрхэнд цус бүрэлдвээс цээж хатгуулах, гэдэс халуун болоод хэрчих мэт болно.
2. Уушгинд цус бүрэлдвээс ханиах, цээж хатгуулах, гүрээ хөших, үе гишүүн өвдөх, нүүр хавдах болно.
3. Элгэнд цус бүрэлдвээс нүдний үүл улаан ба шар, элэгний дээр хийгээд толгой өвдөнө.
4. Дэлүүнд цус бүрэлдвээс гэдэс хатгуулан өвдөнө. Ходоод хоржигнон дэлүүний дээр өвдөнө.
5. Цөсөнд цус бүрэлдвээс хүчгүй, их ундаасах, ханиах, мах арьс шарлах.
6. Бөөр цусаар бүрэлдвээс бэлгэс загатнах, бэлхүүснээс доош яс халуун буцлах мэт болно.
7. Гэдсэнд цус бүрэлдвээс халуун болоод хэрчих мэт болно.
8. Сүүнд бүрэлдвээс сарын хир сүүний ус мэт цувирах, зүрх долгисох, давсаг өвдөөд огших.
9. Хөхөнд цус бүрэлдвээс хөх хавдаад, их өвдөнө.
10. Цус бүрэлдвээс бие хүндэрч явж үл чадна. Гэдэсний доор дүүрч ордослон өвдөх болно<sup>5</sup>.

**Эмчилгээ:**

1. Зүрхэнд цус бүрэлдвээс арүр, шинцагийн тангаар туулгаж, хойно нь зүрхний судлыг хана. Түүний хойно арүрийн тосон эмийг уулгаж, 6-р үеийг төөнө.
2. Уушгинд цус бүрэлдвээс хэвлийн өчүүхэн туулгаар туулгаж, дэжид брэянгу найруул. Хойно нь гурван улааны тосон эм хольж, 4,5 үеийг төөнө.
3. Элгэнд цус бүрэлдвээс гүргэм, шинца, библин, арүрийг архинд хольж туулгаад рүтүнг хана. 8-р үеийг төөнө.
4. Дэлүүнд цус бүрэлдвээс дэвсэн, шинца, дүржэдээр туулгуулж, 11-р үе ба дэлүүн дээр төөнө.
5. Цөсөнд цус бүрэлдвээс арүр, алтанцэцгийн тангаар туулгуулан, хойно нь дэгд нэмээд холь. Цөсний судлыг ханаад 10-р үеийг төөнө.
6. Бөөрөнд цус бүрэлдвээс шинцаг архинд буцалгаж басбэрүү, олмос, бөхөнгийн эвэр нэмэр хийж өг. Булчингийн судлыг хана. Хойно нь таван үндсийг холь. 14-р үеийг төөнө.
7. Гэдсэнд цус бүрэлдвээс гишүүнэ арүрийн тангаар туулга. Таван рашаанаар чийглэж, 17-р үеийг төөнө. Аргалын уушиг, гажаа хийгээд хуучин тосыг өг.
8. Цөсөнд бүрэлдвээс үрийн зүйлээр чийглэж тосыг шүрш. Шинца, зангуу, гажаа, банжингарав, бурам хольж өг.
9. Хөхөнд бүрэлдвээс башига цагаан жилц,

арүрийн танг өгөөд үрийн зүйлийн тосон эмийг холь. Нурууны ар судлыг ханаад 3, 7-р үеийг төөнө.

10. Цус бүрэлдвээс бугын эвэр, олмосыг архитай хольж өг. Лонза, ёвгон судлыг ханаад халуун идээг шүт<sup>5</sup>.

**Засал:**

Цус бүрэлдсэнийг угаах нойтноор засах. Угаах нойтонд хэвлийн болон судлын туулга. Хэвлийн туулгад их өчүүхэн, өчүүхэн хоёр. Судлын нойтон туулгад гадаад, дотоод хоёроор мэтдүгэй. Урьд угаах нойтон туулгад угаах хийгээд тосон засал үйлд. Бэлдэх ёс: ар үр, гишүүн, шинца тус бүрийг хөргөж холь. Цагаан гаа, шинца, олмос, дүржидийг нэмэр эм хийж өг. Хэвлийн өчүүхэн нойтон туулгад олмос, дүржид, ар үр, шинца, цагаан гааг хувь тэгш талхдаад гишүүн буцалгасан шөлөнд хийж өг. Цус бүрэлдсэн гэмийг хоцролгүй

арилгана. Судлын нойтон туулга бэлтгэл хийхэд цагаан гажаагын танг өгөөд цэцэг, шоргоолжны шороо, гүнждийн шаар, тагтааны баасыг аль нэгийг нь архинд буцалгаад өвдөх газар гэдсэн доор жин тавина<sup>5</sup>.

**2. “Анагаах ухааны дөрвөн үндэс” болон бусад сурвалж бичгүүдэд эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний эмэн эмчилгээний харьцуулалт:**

Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчнийг зарим сурвалж бичгүүдэд шалтгаан, нөхцөл, ерөнхий шинж, ангилал, эмийн эмчилгээ, засал гэх мэт тус бүрийн эмчилгээг дэлгэрэнгүй бичжээ. Харин ихэнх сурвалж бичгүүдэд ерөнхий болон тус бүрийн ангилал дээр тулгуурлан эмчилгээг бичсэн байна.

**Table №1.** A comparison of reports describing general and classification medical treatment of gynecological “Qisu” syndromes.

№	A General treatment	Classification and treatment
1	Rashaanii khumkh of Mongolian medicine	Four medical tantras of Medical Science
2	Dugarjav’s therapeutic experience	Lhantav
3	The Book of Diffusion Therapy	4 Rashaan
4	Sarangerelt treatment book	Khukh binderiyaa
5	18-gishuunt /2nd book/	Jiduininnor
6	Convenient editing of the Mongolian hospital	Encyclopedia of Chinese Medicine /Mongolian Medicine/
7	The Four Keys of the Sea of Uvidas	
8	Danzanvanjil tuvduyjam’s treatment prescription	
9	Prenbai of Arur	
10	A gem of medical care	
11	Five novels of Mongolian otochi	
12	Wang Zhu Wo’s therapeutic work	
13	Tungaagajid	
14	Ocean of Uvidas	
15	Formulation of spring medicine to help guide	

Сурвалж бичгүүдэд эмэгтэйн цус бүрэлдсэн өвчнийг ерөнхий шинж тэмдэгт тулгуурлан үндсэн жорыг бичиж тэмдэглэсэн бол зарим

сурвалж бичгүүдэд ангилал бүрийн дагуу нэмэлт жорыг бичсэн байна

**Table №2.** Comparison of drug prescriptions for general and classification medical treatment of gynecological “Qisu” syndromes.

№	Prescriptions for general treatment	Prescriptions for classification treatment
1	Chatsargana-17	Gurwan ur oinmet
2	Pambrai-7	Giwan-6
3	Gishuune-6, 14, 17	Gurgem-7, 13, 17
4	Basberuu -7	Chun-5
5	Zomshin-4, 6, 7	Tanchin-25
6	Oyyu-13	5 rashaanii devteeleg
7	Yaanag nukhur-13	Jugan-7
8	Jonsh-11	Degd-8
9	Melreg tsetseg-7	Zandan-3
10	Braisum-17	Hiin agar-8
11	Rashnamjil	Lotsadgonsel
12	Dedbon-14	Gagol-4
13	Agshirga-3	Tsus-7
14	Jambrai-6	

**Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний мөн чанар:**  
Бүх биеийн чанартай цус шарын хувь дийлэнх шинжийг үзүүлдэг эмэгтэйн ерөнхий өвчин болно. Цус бүрэлдсэн өвчин нь бүх биеийн цусан судлыг дагаж цул саванд сарнидаг онцлогтой болохоор ерөнхийдөө судлын өвчин гэж нэрлэжээ. Цус бүрэлдсэн өвчний шалтгаан нөхцлийг хураангуйлвал сарын хирийн хугацаа, төрсний хойно идээ, явдал мөр, эм, засал эс зохицосноор хий, шар, бадганы эрүүл орших нь харшилдсанаас сарын хирэнд нөлөөлж үржлийн эрхтэний энэ зүйлийн өвчнийг үүсгэж, цаг тухайд нь засаж эдгэрүүлээгүй буюу өвчин нь удааширсанаас цус бүрэлдсэн өвчин болдог байна. Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчин нь монгол эмнэлгийн эмэгтэйн өвчний гол өвчин болох бөгөөд

өвчний гэм нь бүх биед сарниснаар зүрхэнд, уушгинд, элгэнд, дэлүүнд, цөсөнд, бөөрөнд, гэдсэнд, хөхөнд, сүүнд, цус бүрэлдэж тогтсон зэрэг арван зүйлийн цус бүрэлдсэн өвчнийг үүсгэнэ гэжээ<sup>25</sup>.

Бүх биеийн цусны судсыг дагаж цул савыг гэмтээдэг хурц чанартай өвчин. Шалтгаан нөхцлүүдийн улмаас бие махбодын тэнцвэрт үйл ажиллагаа алдагдан хий цус ба бадган цус хямралдаж, зүрх болон бөөрний үйл ажиллагаа алдагдан, хий цусны гүйдэл саатаж улмаар сарын хир, шар усыг хийгээр сарниулснаас уг өвчин үүснэ<sup>2</sup>.

**Хэлцэмж:**

Хүн амын өвчлөлийн дөрөвдүгээр шалтгаан болсон шээс бэлгийн тогтолцооны

өвчин сүүлийн 10 жилийн дунджаар нийт өвчлөлийн 10.6 хувийг эзэлж байна. Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл (10000 хүн амд ногдох) 2020 онд 1084 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 188-аар илүү, өмнөх оноос 36-аар буурсан байна. Шээс бэлгийн тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2020 онд сувганцрын өвчнүүд 47.7 хувь, эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэлт өвчин 15.5 хувь, эм бэлэг эрхтний үрэвсэлт бус өвчин 9.5 хувь, шээс ялгаруулах тогтолцооны бусад өвчин 6.9 хувь, эр бэлэг эрхтний өвчнүүд 7.8 хувь, хөхний өвчин 3.1 хувь, бөөрний түүдгэнцрийн өвчнүүд 2.6 хувь, бөөрний дутмагшил 1.4 хувь, шээс чулуужих өвчин 2.1, цистит 3.2 хувийг тус тус эзэлж байгаагаас<sup>26</sup> харахад эмэгтэйчүүдийн өвчний өвчлөл ихсэх төлөвтэй байна. Үүнийг дагаж эмэгтэйчүүдийн өвчний оношлогоо, эмчилгээний асуудал хөндөгдөж байна. Зөвхөн европ анагаах ухаанаар эмэгтэйчүүдийн өвчний оношлогоо, эмчилгээг хийхээс гадна уламжлалт анагаах ухаанаар оношлох эмчлэх асуудал орхигдох хандлагатай байна.

Уламжлалт анагаах ухаанд эмэгтэйн өвчнийг ерөнхийд нь умайн өвчин таван зүйл, судлын өвчин арван зургаан зүйл, бэтгийн өвчин есөн зүйл, хорхойн өвчин хоёр зүйл лугаа эмэгтэйн гол өвчин гучин хоёр зүйл зэргээр өгүүлсэн байдаг<sup>4</sup>. Үүнээс судлын өвчнийг цус бүрэлдсэн, хий бүрэлдсэн гэж ангилдаг. Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчин нь бүх биед тархах онцлогтой цул савын өвчин бөгөөд бид энэхүү судалгаагаараа эмэгтэйн цус бүрэлдсэн өвчнийг сурвалж бичгүүдэд хэрхэн тэмдэглэснийг харьцуулан судласан.

Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчнийг ерөнхий ба тус бүрийн шинж тэмдэг, тэдгээрийн эмчилгээний жорыг бичиж тэмдэглэсэн бүлэг сурвалж

бичгүүд байна. Ерөнхий шинж тэмдэг болон жорыг тэмдэглэсэн Монгол эмнэлгийн рашааны хумх<sup>6</sup>, Дугаржавын эмчилгээний эмчилгээний туршлага<sup>7</sup>, Сарангэрэлт эмчилгээний ном<sup>8</sup>, Эрдэнийн эрхэсийн зуун анхаарлын бичиг оршвой<sup>9</sup>, 18-гишүүнт /2дугаар дэвтэр/<sup>10</sup>, Монгол эмнэлгийн дөхөм найруулга<sup>11</sup>, Увидасын далайн дөрвөн түлхүүр<sup>12</sup>, Данзанванжил Төвдөннам эмчилгээний жор засал<sup>13</sup>, Арүрийн прэнбай<sup>14</sup>, Анагаах ухааны тус амгалангын эрдэнийн хөмрөг<sup>15</sup>, Монгол оточын таван зохиол<sup>16</sup>, Ван Жу Во-гийн эмчилгээний үйлвэр<sup>17</sup>, Тунгаагажид<sup>18</sup>, Увидасын далай<sup>19</sup>, Гарын авлагад туслах рашааны эм найрлага<sup>20</sup> сурвалж бичгүүд байна. Тус бүрийн шинж тэмдэгийг тэмдэглэсэн Анагаах ухааны дөрвөн үндэс<sup>5</sup>, Лхантав<sup>21</sup>, Дөрвөн рашаан<sup>22</sup>, Хөх биндэръяа<sup>23</sup>, Жидүйниннор<sup>24</sup>, Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь, / Монгол анагаах ухаан/<sup>25</sup> сурвалж бичгүүд байна.

Ихэнх сурвалж бичгүүдэд эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний ерөнхий эмчилгээнд Чацаргана-17, Гишүүн-6, Зомшин-4, 6, 7, Оюу-13, Янаг нөхөр-13, Жонш-11, Мэлрэг цэцэг-7, Врайсүм-17, Рашнамжил эмүүдийг тэмдэглэсэн байна.

Б.Дэжидмаа (2013) нарын “Уламжлалт анагаах ухаанд хэрэглэгддэг Зомшин-6 тан, Дэлт харгана ургамлын цусны бүлэгнэлтэнд үзүүлэх нөлөөг судлах” нэг сэдэвт бүтээлд Ишданзанванжилын туурвисан “Жүри дошал” зохиолд Зомшин-6 танг хий, халууныг боловсруулах, сарын хирийн хямралыг тэгшитгэх, царцсан цусыг шингэлэх, эмэгтэйчүүдийн хий цус бүрэлдсэн өвчний үед хэрэглэнэ гэжээ. Зомшин-6, дэлд харганы бэлдмэл, суман модны бэлдмэл нь тромбын бүтцийн үндсэн элемент болох фибриний хэмжээг бууруулж, судасны хөндийг чөлөөтэй байлгаж, судас тромбоор бөглөрөхөөс сэргийлэх үйлдэлтэй нь судалгаагаар тогтоогдсон<sup>27</sup> нь зомшин-6 тан эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний чухал үндсэн эм найрлага болох нь тус судалгаанаас харагдаж байна.



Мөн Ао Да Ган (2016) нарын “Гурван халуунаар өдөөгдсөн цусны халууны эмгэг загварт суман мод-4 тан (зомшин-4) тангийн үзүүлэх нөлөө” нэг сэдэвт бүтээлд тус өвчинд хэрэглэдэг жор болох зомшин-4 тан нь гурван халууны нөлөөгөөр нэмэгдсэн улаан эсийн бодит тоон хэмжээ түүний харгалзах үзүүлэлтүүд болох гемоглобин болон гематократыг багасгадаг ( $p < 0.05$ ) нөлөөтэй нь тогтоогдов. Суман мод-4 нь ялтсын тоо хэмжээг бууруулах нөлөө үзүүлсэн. Суман мод-4 тангийн цус шингэрүүлэх үйлдэл нь ялтсын тоог бууруулах түүний үйлдэлтэй нь холбоотой байж болох юм гэдэг нь уг судалгаагаар тогтоогдсон<sup>28</sup> нь тус найрлагыг эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний ерөнхий эмэнд багтахыг илтгэж байна. Суман мод-4 тан нь өтгөрсөн цусыг шингэрүүлэх, сарын хирийг ирүүлэх чадалтай юм<sup>29</sup>.

#### Дүгнэлт:

1. Анагаах ухааны дөрвөн үндэс зохиолд эмэгтэйчүүдийн цус бүрэлдсэн өвчний ерөнхий болон ангилал бүрийн шинж тэмдэгийг дурьдан, тус бүрийн эмчилгээний эмийн жорыг дэлгэрэнгүй өгүүлж, засал эмчилгээг тодорхой бичсэн байна.
2. Анагаах ухааны дөрвөн үндэс, Лхантав, Дөрвөн рашаан, Хөх биндэръяа, Жидүйниннор, Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь зохиолуудад эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний шинж тэмдэгийг ангилал тус бүрээр өгүүлж, эмчилгээний жорыг задлан дэлгэрэнгүй бичжээ. Харин бусад зохиолуудад ерөнхий шинжид тулгуурлан эмчилгээг бичсэн байна. Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний эмчилгээнд 33н нэр бүхий тан, талх эмүүд багтаж байна. Ихэнх сурвалж бичгүүдэд эмэгтэйн цус бүрэлдсэн өвчний ерөнхий эмчилгээнд Чацаргана-17, Гишүүн-6, 14, 17, Басбэрүү-7, Зомшин-4, 6, 7, Оюу-13, Янаг нөхөр-13, Жонш-11, Мэлрэг цэцэг-7, Врайсүм-17, Рашнамжил, Дэдбон-14, Агширга-3, Жамбрай-6 эмүүдийг дурьдсан ба ангилал бүрийн эмчилгээг тухайн байдалтай нь уялдуулсан байна.
3. Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчин нь цус шарын дийлэнх шинжээр голлосон бүх биеийн чанартай өвчин. Цусаар өвчнийг сарниулж цул савыг адил биш байдлаар гэмтээж цусны шинж голлож, шарын шинж хавсарч цул савын бүрэлдсэн өвчнийг үүсгэдэг байна.

#### Ном зүй:

1. <https://hospital.manbadatsan.mn>. Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчин, 2020,5.
2. Алимаа Т., Цэнд-Аюуш Д., Цэрэнцоо Б., Батнайрамдал Ч., Баярмаа Б. Монгол анагаах ухааны өвчнийг анагаах увидас, Улаанбаатар, 2013, 226-227
3. Жигмэдданзанжамц. Зоригт хамбын эмчилгээний үйлвэр, Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2012,3,124-125
4. Ютог Ёндонгомбо.Увидасын үндэс.УБ, 2012.395
5. Ютог Ёндонгомбо. Анагаах ухааны дөрвөн үндэс. Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 1987, 9, 693-698.
6. Намжил Б. Монгол эмнэлгийн рашааны хумх. Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2016, 10, 200, 202.
7. Дугаржав А. Дугаржавын эмчилгээний туршлага. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1992, 12, 271-273.
8. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, Сарангэрэлт эмчилгээний ном, 1999, 4, 33,
9. Гончигбаатар, Эрдэнийн эрхэсийн зуун анхаарлын бичиг оршвой, Үндэсний

- хэвлэлийн хороо, 1986, 7, 192.
10. Ютог Ёндонгомбо. 18-н гишүүнт. Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2016, 11, 923-926.
  11. Монгол эмнэлгийн дөхөм найруулга. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1976, 4, 68-69.
  12. Жамбалцүйнхөр. Увидасын далайн дөрвөн түлхүүр. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 2010, 5, 226-229.
  13. Данзанванжил төвдөнням, Данзанванжил Төвдөннэмын эмчилгээний жорын засал, Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1995, 12, 48.
  14. Лүнрэгдандар, Арүрийн прэнбай, Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2015, 9, 381, 385-386.
  15. Гарма. Анагаах ухааны тус амгалангын эрдэнийн хөмрөг/Доод/. Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 674-682, 684-686.
  16. Лувсанданзанжалсан. Монгол оточын таван зохиол. Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2014, 11, 83-84.
  17. Ван Жун Во. Ван Жун Вогийн эмчилгээний үйлвэр. 1985, 12, 305-306.
  18. Жигмэдданзанжамц. Тунгаагажид. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999, 97 -98.
  19. Лувсанданзанпрэнлэй. Увидасын далай. Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо 2019, 7, 347-348.
  20. Жалсандэсэр. Гарын авлагад туслах рашааны эмийн найрлага. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1986, 2, 174-176.
  21. Дэсрид Санжаажамц. Лхантав. Үндэсний хэвлэлийн хороо, 1987, 8, 479-480, 482-485
  22. Ишбалжир. Дөрвөн рашаан. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1998, 12, 200-201.
  23. Дэсрид Санжаажамц. Хөх Биндэръяа. Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2016, 10, 252 -264.
  24. Лувсанчоймбал. Жидүйниннор. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо ,1999, 10, 269-275.
  25. Бай Чин Юүн. Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь /Монгол анагаах ухаан/. Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 1987, 7, 325-328.
  26. Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт , 2020, 146-148.
  27. Дэжидмаа Б. “Уламжлалт анагаах ухаанд хэрэглэгддэг заримт эмт бодисын цусны бүлэгнэлтэнд үзүүлэх нөлөөг судлан асуудалд, Дэлт харгана /Зомшин-6 тан/ ургамлын цусны бүлэгнэлтэнд үзүүлэх нөлөөг судлах” нэг сэдэвт бүтээл. 2013.
  28. Ао Да Ган. “Гурван халуунаар өдөөгдсөн цусны халууны эмгэг загварт суман мод-4 тан (зомшин-4) тангийн үзүүлэх нөлөө” нэг сэдэвт бүтээл. 2016.
  29. Багана. Монгол анагаах ухааны эм найрлагын судлал. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 2007, 7, 273.

*Уншин танилцсаж, нийлтэх санал өгсөн:  
АУ-ы доктор, дэд профессор Х.Туул*